



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/80

Баян-Овоо

**Замын хөдөлгөөнийг хэсэгчлэн
хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хүүхэд, эцэг эх, гэр бүлтэйгээ хамтдаа аз жаргалтай баярлах боломжийг бүрдүүлэн хүүхэд зам, тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлж, “Дадал марафон-2024” тэмцээн зохион байгуулах зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг “Автомашингүй өдөр” болгон уриалсугай.

2.“Автомашингүй өдөр”-ийн маршрутыг “Дэлүүн болдог” дэлгүүрийн уулзвараас “Төгөлдөр супер маркет” хүртэл өглөөний 09.00 цагаас 16.00 цаг хүртэл, “Төгөлдөр супер маркет”-ын уулзвараас Бөөрбулагийн замын төгсгөл хүртэл 08.30 цагаас 12.00 цагийн хооронд замын хөдөлгөөнийг хэсэгчлэн түр хязгаарласугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, ахмад (Ц.Өлзийбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

01-0000204